


БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д эм, эмнэлгийн
хэрэгсэл нийлүүлэх шууд гэрээ.

2016 оны 2 сарын 18

НИЙЛҮҮЛЭГЧ:

МӨНХИЙН ТУН ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.МУХАМЕДЖАН



Улаанбаатар хот

Нэг талаас *Цус сэлбэлт судлалын үндэсний төв* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Мөнхийн тун ХХК* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 02 сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд цусны хүүдий, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 2016 он 01” дугаартай тендерийн “Эм, эмнэлгийн хэрэгсэл”-ийн 15-р багцын (цаашид “бараа” гэх) нийт 10,000,500 (арван сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт 10,000,500 төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

1.4 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 02 дугаар сарын 18-наас 2016 оны 9 дүгээр сарын 01-ний дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- 1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
- 1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, төхникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2 Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.
- 3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.
- 3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
 - 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцэх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж
Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Мөнхийн тун ХХК-ийн
ДАРХААНЫ АЙМЫН
Эм зүйч Ө.Ариунзаяа
О. Ариунзаяа
Мөнхийн тун
Хаяг: Чингэлтэй дүүрэг, 3-р хороо
Мандухай зочид буудлын хажууд өөрийн байр
Утас: 70115653 , Факс: 976-11-312951

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

огноо: 2016.02.18

НТШ-ЫН дугаар : 2016 он 01

ЭМ, ЭМИНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ.

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу өрөнхий нэршил	Савалалтын хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Денутрат спирт	Spiritus denaturatus	литр	260	1500	390000
2.	Хөвөн	Cotton	ширхэг	2540	700	1778000
3.	Бинт	bandage	ширхэг	300	750	225000
4.	Дуслын систем	Infusion set	22G	1500	300	450000
5.	Нэг удаагийн халад	Single use hospital gown	ширхэг	700	1500	1050000
6.	Цэвэр спирт 96	96% Spiritus	литр	35	8000	280000
7.	Устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxide	литр	40	3500	140000
8.	Жугт	harness	ширхэг	40	2000	80000
9.	Борийн хүчил	Boric acid	ширхэг	10	14000	140000
10.	Хүхэр хүчлийн зэс	Cupric sulfate	литр	5	27500	137500
11.	Пластер	Medical plaster	ширхэг	300	350	105000
12.	Уян болот	Elastic bandage	ширхэг	6100	850	5185000
13.	Үнсгүй фильтер	Filter papers	ширхэг	20	2000	40000
		Нийт				10000500

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ- ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ.

№	Бүтээгдхүүний нэр	Эмийн олон улсын буюу өрөнхий нэршил	Савалалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийтүүлэлтийн хуваарь	
					2016 оны 2 сар	2016 оны 5 сар
1.	Денутрат спирт	Spiritus denaturatus	литр	260	100	100
2.	Хөвөн	Cotton bandage	ширхэг	2540	1000	540
3.	Бинт	Infusion set	ширхэг	300	115	70
4.	Дуслын систем	22G		1500	600	300
5.	Нэг удаагийн халад	Single use hospital gown	ширхэг	700	250	200
6.	Цэвэр спирт 96%	96% Spiritus Hydrogen peroxide	литр	35	13	9
7.	Үстөрөгчийн хэт исэл	harness	ширхэг	40	15	15
8.	Жгут	Boric acid	40	15	15	10
9.	Борийн хүчил	Cupric sulfate	ширхэг	10	4	2
10.	Хүхэр хүчлийн зэс	Medical plaster	ширхэг	5	2	1
11.	Пластер	Elastic bandage	ширхэг	300	120	60
12.	Уян боолт	Filter papers	ширхэг	6100	2300	1500
13.	Үнсгүй фильтер			20	7	6